

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
САЙД, САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2018 оны <sup>11</sup> дүгээр  
сарын <sup>13</sup> ны өдөр

Дугаар <sup>А-429/257</sup>

Улаанбаатар  
хот


Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн санд  
<sup>2018 оны 11 сарын 30-ны</sup>  
өдрийн <sup>4048</sup> дугаарт бүртгэв.

Жагсаалт батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.14 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалт"-ыг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох байгууллагуудад мэдэгдэн, мэргэжил, арга зүйгээр ханган ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар /Г.Нямдаваа/-т, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар /Ж.Ганбат/-т тус тус үүрэг болгосугай.



Байгаль орчин, аялал жуулчлалын Сайд, Сангийн сайдын  
хамтарсан 2018 оны 11 дүгээр сарын 13 ны өдрийн  
# 429/257 дугаар тушаалын хавсралт

Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон  
импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалт

Дараах үйл ажиллагаа эрхлэгч нь бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав баглаа  
боодлоос үүсэх хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах,  
сэргээн ашиглах, булшлах үйл ажиллагааг хариуцна. Үүнд:

1. Хуванцар сав суулга, түүхий эд;
2. Нийлэг уут түүний түүхий эд;
3. Бүх төрлийн зай хураагуур, аккумулятор;
4. Хими цэвэрлэгээний бодис;
5. Шилэн лонх сав;
6. Өндөр даралтат сав;
7. Химийн хорт болон аюултай бодисын сав баглаа боодол;
8. Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн сэлбэг хэрэгсэл, дугуй;
9. Бүх төрлийн машин механизмын тос, тосолгооны бүтээгдэхүүн;
10. Мөнгөн ус агуулсан бараа бүтээгдэхүүн;
11. Аюултай хог хаягдал.

